

БАТЛАВ.
ХАВДАР
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



БАТЛАВ.

"БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ"
ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ



ЦАМАРСАНАА

2022 оны 5 сарын 18 өдөр

№ 2022/141

Улаанбаатар хот

Энэхүү хамтран ажиллах гэрээг Монгол Улсын Иргэний хуулийн 476-482 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн нэг талаас 5164753 регистрийн дугаартай "Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ-ыг төлөөлж **Захиргаа удирдлагын хэлтсийн дарга Г.Түвшинжаргал** /цаашид "байгууллага" гэх/, нөгөө талаас Баянзүрх дүүрэг, Нам-Ян-Жугийн гудамжинд орших Хавдар судлалын үндэсний төв /цаашид "Эмнэлэг" гэх, хамтад нь "Талууд" гэх/ нар дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Гэрээний зүйл

- 1.1. Энэхүү гэрээний ЗОРИЛГО нь эрүүл мэндийн хуульд заасан хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих зорилгоор хүлээсэн үүргээ биелүүлэх үүднээс байгууллагын ажилчдыг өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, тэдний ажлын чадвар, эрүүл мэндийг нөхөн сэргээх зорилгоор нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг шинжилгээнд хамруулж эрүүлжүүлэх, хэвтүүлж эмчлэх зэрэг эмнэлгээс байгууллагын ажилтнуудад дээрх үйлчилгээг үзүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Гэрээний хугацаа, төлөх хөлс

- 4.1.1 Байгууллага нь байгууллагын ажилтнуудыг хавдар өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 2022 оны 5 дугаар сарын 26-ны өдөр Урьдчилан өгөх шаардлагатай шинжилгээг "Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ-ын байранд ирж нэгдсэн журмаар авах ба 5 дугаар сарын 28 -ны өдөр *Хавсралт 1-д* заасан эмч нарын бүрэлдэхүүнтэй үзлэг, шинжилгээг ХСҮТ дээр зохион байгуулна.
- 2.1. Урьдчилан сэргийлэх үзлэгийн хөлс нь *Хавсралт 1-д* заасан тарифаар мөрдөнө.
- 2.2. Урьдчилан сэргийлэх үзлэгт нийт **163** (Эрэгтэй-74, эмэгтэй-89) хүн хамрагдах ба үзлэг, шинжилгээний төлбөр **40,572,000** (Дөчин сая таван зуун далан хоёр мянга) төгрөг ба урьдчилгаа 80 хувийг үзлэг, шинжилгээ хийгдэхээс өмнө Хавдар судлалын үндэсний төв, регистрийн дугаар 9128832, Төрийн сан банк 100900020019 тоот дансанд шилжүүлж, үлдэгдэл төлбөрийг үзлэг хийгдэж зөвлөгөө бичигдсэний дараа гүйцэтгэлээр тооцож шилжүүлнэ.

- 2.3. Үзлэг, шинжилгээнд нэмэлт хүн хамрагдсан тохиолдолд төлбөрийг гүйцэтгэлд тулгуурлан төлж барагдуулна.

Гурав. Байгууллагын эрх, үүрэг

3.1 Байгууллагын үүрэг:

- 3.1.1 Энэхүү гэрээнд заасны дагуу үзлэгийн хөлсийг төлөх;
- 3.1.2 Ажилтнуудыг үзлэгийн өдөр, цагт нь бүрэн хамруулах;
- 3.1.3 Үзлэгт хамруулах ажилчин албан хаагчдын нэрсийн жагсаалтыг хавсралтын дагуу ... хувь гарган 2 хоногийн өмнө ирүүлэх;

3.2 Байгууллагын эрх:

- 3.2.1 Байгууллага нь ажилтнуудаа нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулах, шаардлагатай тохиолдолд дарааллын дагуу хэвтэж эмчлүүлэх;
- 3.2.2 Хэрэв эмнэлэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг нэг талын санаачлагаар цуцлах эрхтэй.

Дөрөв. Эмнэлгийн эрх үүрэг

4.1 Эмнэлгийн үүрэг

- 4.1.2 Эмнэлэг нь урьдчилсан үзлэгт хамрагдахаар ирсэн ажилтнуудыг хүлээн авч хүндрэл учруулахгүйгээр хөнгөн шуурхай үйлчлэх;
- 4.1.3 Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас тухайн үед үзлэгт хамрагдаж чадаагүй албан хаагчдыг нөхөн үзлэг хамруулах;
- 4.1.4 Урьдчилан өгөх шаардлагатай шинжилгээг “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын байранд ирж нэгдсэн журмаар авах
- 4.1.5 Үзлэгийн хуудсанд нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгийг нэгтгэж ерөнхий эмч дүгнэлт хийж, эрүүл мэндийн дүгнэлтийг ажилтан тус бүрээр гаргах байгууллагын Хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтанд ажилтан бүрийн оношийг нэгтгэн excel програмын бүртгэл хүлээлгэн өгөх
- 4.1.6 Үзлэгийн дүнг нэгж тус бүрээр гаргах буюу нэгтгэсэн байдлаар эрүүл мэндийн дүгнэлт гаргаж өгөх, цаашид анхаарах заавар зөвлөмж, эрүүл мэндийн хувьд анхаарах ажилтнуудын судалгааг гаргаж өгнө; Үзлэгийн явцад нарийвчилсан шинжилгээ хийлгэх, онош тодруулах шаардлагатай ажилтнуудыг зөвлөх эмчид үзүүлж дүгнэлт гаргуулна;
- 4.1.7 Өвчний талаар дүгнэлт судалгааг үндэслэн цаашид авах арга хэмжээний зөвлөмжийг байгууллагын удирдлагуудад танилцуулах;

4.2 Эмнэлгийн эрх

- 4.2.1 Байгууллагын ажилчдад үзлэг хийсний хөлсөө энэхүү гэрээнд заасны дагуу нэхэмжлэл авах;

Тав. Хариуцлага

- 5.1 Хэрэв эмнэлэг гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд байгууллагын гомдлыг барагдуулна.

Зургаа. Маргаан шийдвэрлэх

- 6.1 Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зөрөлдөөн, маргааныг талууд зөвшилцөх аргаар шийдвэрлэнэ.
- 6.2 Хэрэв 6.1-т заасан аргаар маргааныг шийдвэрлэж чадахгүй бол Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 6.3 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд оруулах нэмэлт өөрчлөлтийг зөвхөн бичгээр үйлдэх бөгөөд гэрээнд оролцогч талуудын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөрт тооцогдоно.

Долоо. Бусад

- 7.1 Энэхүү гэрээг 3 хувь үйлдэж тал тус бүр нэгийг хадгалсан нь хууль зүйн хувьд ижил хүчинтэй.
- 7.2 Энэхүү гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцож нэмэлт гэрээ байгуулах замаар шийдвэрлэнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

**“ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ
ТӨВ”-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

ЭДИЙН ЗАСАГ, ТӨЛӨВЛӨЛТ,
МОНИТОРИНГИЙН АЛБАНЫ
ДАРГА


Б.ДЭНСМАА

**“БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ”
ТӨҮГ-Г ТӨЛӨӨЛЖ:**

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА


Г.ТҮВШИНЖАРГАЛ

САНХҮҮ, ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА


Г.ГАНТУУЛ

Хаяг:

Холбоо барих утас:

Данс:

Цахим шуудангийн хаяг:

Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Их
тойруу 1, Барилгын хөгжлийн төв
ТӨҮГ

Утас: 7011-0298